

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ҮНДЭСНИЙ ИХ БАЯР НААДМЫН ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬД ТАВЬСАН ХОРИГИЙН ТАЛААР ТӨРИЙН  
БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНООС ГАРГАСАН САНАЛ, ДҮГНЭЛТ**

2013 оны 7 дугаар  
сарын 8-ны өдөр

Улаанбаатар  
ХОТ

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын  
гишүүн Су.Батболд**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын 2013 оны 7 дугаар сарын 5-ны өдөр баталсан Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд Монгол Улсын Ерөнхийлөгч 2013 оны 7 дугаар сарын 8-ны өдөр бүхэлд нь хориг тавьсан байна.

Монгол Улсын Ерөнхийлөгч Үндэсний их баяр наадмын тухай хуулийг олон улсын жишиг, өнөөгийн хөгжлийн чиг хандлагыг харгалзан, нийт ард иргэдээр нээлттэй хэлэлцүүлж, мэргэжлийн байгууллагуудын саналыг авч, өргөн хүрээнд шинэчлэн найруулах нь зүйтэй гэж үзсэн байна.

Төрийн байгуулалтын байнгын хороо уг асуудлыг 2013 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар асуудлыг хэлэлцэх явцад Улсын Их Хурлын гишүүн Д.Эрдэнэбат, Ж.Батзандан нар “Үндэсний уламжлалт наадмыг хуульчлах нь буруу иймээс хоригийг хүлээж авах нь зүйтэй” гэсэн санал гаргасан.

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2013 оны 7 дугаар сарын 5-ны өдөр баталсан Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд бүхэлд нь тавьсан хоригийг хүлээн авах эсэх асуудлаар санал хураалт явуулахад Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн дийлэнх олонх нь хоригийг хүлээн авах нь зүйтэй гэж үзэв.


Байнгын хороо хоригийг хүлээн авах нь зүйтэй гэж үзсэн тул Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг хэлэлцэх нь зүйтэй гэсэн санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн дийлэнх олонх нь дэмжиж, уг хуулийн төслийг нэгдсэн хуралдаанд оруулах нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд тавьсан хоригийн талаар Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА**



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТОГТООЛ**

2013 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Дугаар

Улаанбаатар  
хот

**Ерөнхийлөгчийн хоригийн тухай**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

1.2013 оны 7 дугаар сарын 05-ны өдөр баталсан Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн зөвшөөрсүгэй.

2.Энэ тогтоолыг батлагдсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2013 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ҮНДЭСНИЙ ИХ БАЯР НААДМЫН ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ  
ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** 2013 оны 7 дугаар сарын 05-ны өдөр баталсан Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг хүчингүй болсонд болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг батлагдсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг